



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 05 сарын 25 өдөр

Дугаар 11251

Улаанбаатар хот

Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төвийн балансаас хөрөнгө шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2020 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 27,500,000 /хорин долоон сая таван зуун мянган/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төвийн балансад шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төв /Ц.Лхагва/-д зөвшөөрсүгэй.

2. Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, зарчмыг баримтлан бүртгэж авахыг Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төв /Ж.Болотуяа/-д даалгасугай.

3. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төв /Ц.Лхагва/-д, Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төв /Ж.Болотуяа/-д тус тус үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ

115070000589

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын  
2020 оны <sup>05</sup>... дугаар сарын <sup>25</sup>... өдрийн  
<sup>0231</sup>... дугаар тушаалын хавсралт

Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төв

төгрөгөөр

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Ашиглалтанд орсон онос	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Шилжүүлэн авах байгууллага
Машин тоног төхөөрөмж										
1	Гематологийн аппарат	URIT 5380	2019.07.01	ширхэг	1	27,500,000	27,500,000	4,575,808	22,924,192	Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төв
Машин тоног төхөөрөмжийн дүн					1	27,500,000	27,500,000	4,575,808	22,924,192	